



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 11/293

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, уг тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.2.13, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 221 тогтоолоор баталсан “Төрийн алба хаагчдын орон сууцны дэд хөтөлбөр”-ийн 3.2.1 дахь хэсэг, Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын хавсралтын 5.1.2, Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028” арга хэмжээний 4.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц барьж, байгуулан орон сууцжуулах боломжтой компанийн судалгааг гарган, сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Засаг даргын орлогч

Гишүүд

Засаг даргын Тамгын газрын дарга

Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн Засаг даргад 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (З.Бямбажав)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн менежер (Л.Цэеэрэгзэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

1525010843